

А.Энхтөр¹✉, К.Дархан², Б.Напил²✉,
Б.Нурболат², Ц.Буянхишиг¹, Г.Батболд¹,
С.Далантай¹

¹ШУА-ийн Археологийн хүрээлэн, Монгол улс, Улаанбаатар-13330,
Энхтайвны өргөн чөлөө, ШУА-ийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр
²Олон улсын Түрэг академи, Казахстан улс, Астана хот

Кутлук хааны тахилын онгон цогцолбор, гэрэлт хөшөө

Товчлол. Монгол улсын ШУА-ийн Археологийн хүрээлэн, Олон Улсын Түрэг Академи хамтран 2019, 2022 онд Архангай аймгийн Хашаат сумын Номгоны хөндийд эртний Түрэгийн үеийн тахилын онгон цогцолборт археологийн хайгуул, малтлага судалгааг хийсэн юм. «Номгон-2» тахилын онгон цогцолборт хийсэн малтлагын явцад Түрэгийн хожуу хаант улсыг сэргээн тохинуулагч Кутлук хаанд зориулсан дурсгал болох нь тодорхой болсон. Кутлук «Элтгерис» хаан нь алдарт Билгэ хаан, Күлтегин жанжины эцэг юм. Малтлагаар хүн чулуун хөшөөний малгайтай толгойн болон доод хэсэг, хүн чулууны хоёр толгойн хугархай, хоёр чулуун хонь, хоёр гүентэй чулуун арслан, дээврийн ваар, нүүр ваар, тоосго, дундаа нүхтэй тахилын шоо чулуу зэрэг эд өлгийн зүйлийг илрүүлсэн юм. Мөн зэл чулуунаас «эшир» (ашина) аймгийн янгир тамга олдсон. Нүүдлчдийн түүхэнд тэр тусмаа Түрэг судлалын хувьд бичээстэй гэрэлт хөшөө шинээр олдож байгаа нь онцгой шинэ нээлт болж байна. Археологийн малтлагын явцад гэрэлт хөшөөний дээд хэсэгт нь хос чоно, бадамлянхуа цэцгийн дүрс сийлсэн бөгөөд эртний Түрэг, Согд, Брахми бичгээр сийлсэн хос хэлний бичээс бүхий гэрэлт хөшөө анх удаа олдож байгаа юм. «Кутлук каган» гэсэн бичээс нь эртний Түрэг, Согд бичгийн хэсэгт хос хэлээр тод бичигджээ.

Түлхүүр үгс: Кутлук каган, Елтерис каган, эртний Түрэг бичиг, Согд бичиг, Брахми бичиг, гэрэлт хөшөө, эртний түрэгийн тахилын онгон цогцолбор, чулуун арслан, чулуун хонь, шоо чулуу, дээврийн нүүр ваар, тоосго

A.Enkhtur¹✉, K.Darkhan², B.Napil²✉,
B.Nurbolat², Ts.Buyankhishig¹, G.Batbold¹,
S.Dalantai¹

¹Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences, Building-1,
Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia
²International Turkic Academy, Astana, Kazakhstan

Qutluq qaghan's Altar and Monument

Summary. International Turkic Academy and the Mongolian Academy of Sciences jointly carried out archaeological excavation at nine burial sites, which date back to the old Turkic period, in the Nomgon valley in Khashaat soum, Arkhangai aimag (province) in 2019-2022. During the “Nomgon-2” excavations, we conclude that the burial site was dedicated to the restorer of the Second Turkic empire, Elteris, who reigned as Qutluq Qaghan in 682-692, the father of Bilge Qaghan and Kültegin. The capped head and lower part of the Qaghan statue, two smaller pieces of a stone head statue, two stone statues of sheep, a stone statue of a lion with two cubs, roof ceramics, surface ceramics, bricks, a sacred square stone with a center hole, and other historical objects have been found from the sacred sites. At the sacred site's зэл чулуунаас the seal of the “eshir” (Ashina) royal dynasty was found. The discovery of this stone stele with inscriptions is significant for global nomadic civilization and Turkic studies. During the archeological excavations, it is found for the very first time that the stele, of which two wolves and lotus are inscribed in the upper part, with inscriptions in Old Turkic, Sogdian, and Brahmi scripts. In particular, “Qutluq Qaghan” is clearly written in Old Turkic and Sogdian.

Keywords: Qutluq Qaghan, Elteris, Old Turkic monuments, Sogdian inscriptions, Brahmi scripts, stele, Old Turkic burial sites, stone lion statue, stone хуу statue, square stone, roof surface ceramics, bricks

Удиртгал

Монгол улсын Архангай аймаг, Хашаат сумын «Номгоны хөндий» хэмээх тэгш тал дээр эртний түрэгийн 9 тахилын онгон цогцолбор байдаг. Энэхүү «Номгоны хөндийн» баруун хойд тал нь Их Номгон уул, зүүн урд тал нь Бага Номгон уулаар хүрээлэгдсэн байдаг. Онгон цогцолборуудын хойд төгсгөлд «Хөгнө-Хан» хэмээх хурц оргил бүхий өндөр уул байдаг. Энэ уулын урд талд «Элсэн тасархай» хэмээх цайвар шаргал өнгийн элсэн манхан баруунаас зүүн тийш гучаад километр үргэлжилдэг. Тарна гол нь эдгээр манхнаас урагш урсдаг ажээ.

Судалгааны тойм: «Номгоны хөндий» дэх онгон цогцолборуудыг анх 2000 онд Монгол Улсын нэрт археологич, түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Довдойн Баяр тус нутгийн сургуулийн биеийн тамирын багш Г.Дондовын хамт анхлан олж тогтоосон байна [Баяр 2010; 2012: 6-25; Ваяр 2014: 106-112].

2001 онд археологич А.Энхтөр тусгайлан судалж, цогцолборуудын дэвсгэр зургийг гаргаж, 9 тахилын онгон цогцолборын ерөнхий шинж чанарыг «Номгон-1-9» гэж тодорхойлсон ажээ [Энхтөр 2003: 25].

2007 онд “Монголын Үндэсний Түүх”-ийн музейн судалгааны багийн хамт олон тус цогцолбор дурсгалын ерөнхий тодорхойлолтыг хийж бүртгэн баримжуулсан [Очир нар. 2009: 35-47].

2012; 2013 онд “Соёлын Өвийн Үндэсний Төв”-ийн баг бүрэлдэхүүн тус газарт очиж дахин бүртгэн баримтжуулалт хийсэн юм [Энхбат нар. 2012: 40,41; мөн 2013: 86].

2019 оноос ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн, Казахстан улс дахь “Олон Улсын Түрэг Академи”-ийн хамтарсан археологийн судалгааны хээрийн шинжилгээний анги “Номгон-2” төслийг хэрэгжүүлэн хайгуул, малтлага гэсэн үндсэн чиглэлийн дагуу ажилласан [Цэвээндорж нар. 2019: 41]. Хоёр улсын хамтарсан төсөл нь 2022 оноос гэрээгээ шинэчлэн ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй хамтран ажиллах болсон. Тус төслийг монголын талаас Археологийн хүрээлэнгийн дундад зууны салбарын эрхлэгч доктор (Ph.D), дэд процессор А.Энхтөр, Түрэг Академийн талаас Д.Кыдырали нар удирдан ажиллаж байна [Энхтөр нар. 2022].

Өгүүлэн буй тахилын онгон, цогцолбор дурсгалт газруудад 2019

оныг хүртэл шинжлэх ухааны нарийвчилсан хайгуул, малтлага судалгаа хийгдээгүй. Урьдчилсан судалгаагаар бид «Номгон»-ы тахилын онгон, цогцолбор дурсгалуудыг дараах байдлаар томъёолон авч үзсэн юм. Учир нь дурдсан цогцолборуудын чулуун хөшөө, зарим бүрэлдэхүүн хэсгүүдийг нүүлгэн шилжүүлсэн, анх байрласан газраасаа хөдөлж өөрчлөгдсөн тохиолдлууд цөөнгүй билээ.

Номгоны хөндийн тахилын онгон бүхий цогцолбор дурсгалууд:

Дээрх газарт эртний Түрэгийн II-р хаант улсын үед холбогдох тахилын онгон, түүний бүрэлдэхүүн хэсэг болох хөшөө чулуу, зэл чулуу бүхий цогцолбор дурсгалт нийт 9 газарт мэдэгдэж байна. Зарим дурсгалын хөшөө чулуу анхны байрлалаа алдаж өөр газарт байрласан байдал мэдэгдэнэ. Эдгээр цогцолбор дурсгалуудыг тус бүрт нь ангилан авч үзвэл:

Номгон-1. Их Номгон, Бага Номгон хайрхнуудын дунд хэсгийн уудам хөндийг «Номгоны их хөндий» хэмээн нутгийн иргэд нэрлэдэг. Их номгоны хөндийн урд захад төв замаас хойд зүгт 700 м орчим зайд эл дурсгал байрлана. Дөрвөлжин шороон хэрэмтэй ба голдоо овгор шороон байгууламжтай. Шороон хэрэм зүүн зүгт чиглэсэн үүдтэй. Байгууламжийн хэрмийн урт 53 м, өргөн 42 м, зузаан 8 м. Хэрмийн төвд байрлах байгууламж голдоо хонхор. Голын байгууламжийн дээгүүр хөх саарал өнгөтэй дээврийн ваарын үлдэгдэл их хэмжээгээр тархсан ажээ. Дурсгалын зүүн талд үүд голлож толгойгүй, суугаа хүн чулуун хөшөө бий. Хүн чулууны урд талд 2.6 м зайд хүн чулуун хөшөөний доод хэсгийн хугархай газарт зоолттой бий. Тус байгууламж



Зураг 1. «Номгон-1» онгон цогцолборын зэл ба хүн чулуу.


24.1 x 18.3 м хэмжээтэй. Хэрмийн үүднээс зүүн зүгт 200 м орчим зайд 11 ш зэл чулууг цувуулан тавьсан ба эдгээр зэл чулуу одоо бүгд унасан байна.

Номгон-2. «Номгон-1» цогцолбороос хойш 500 метрийн зайд дурдсан тэгш талд байрладаг. Цогцолборын овоорсон хөрс тод харагдаж байна. Цогцолборын төвд нэг эгнээ шоо чулуу, хавтгай чулуу - 2 ширхэг байна.

Номгон-3. 2-р дурсгалт газраас хойд зүгт 600 м орчим зайд байрлана. Өргөргийн дагуу зэрэгцээ тахилын 2 ш дөрвөлжин хавтан чулуун байгууламж байна. Эхний байгууламж ертөнцийн зүгээр чанх урд талд нь байрлана. Байгууламжийн зүүн талын хашлага чулуу байхгүй ба баруун хойд талдаа 1 ш том хавтгай хашлагатай чулуу үлдсэн. Хашлага чулуу газраас дээш 13 см цухуйсан. Хэмжээ нь 230 x 232 см. Дараагийн тахилын хавтан өмнөх хашлаганы хойд талд 37 см зайд зэрэгцээ байрлана. Хойд болон зүүн талд 1 ш том хавтгай чулуун хашлага үлдсэн нь газраас дээш 29 см ил ажээ. Хойд талын хашлага чулуу 68 x 10 см хэмжээтэй ба гадна талаараа жижиг чигжээс чулуутай. Зүүн талын хашлага чулуу 110 x 24 см хэмжээтэй. Тахилын байгууламж 267 x 330 см хэмжээтэй. Хашлага чулууны гадаргад хээ байхгүй. Мөн зэл чулуу босгосон зүйл мэдэгдэхгүй ажээ.

Номгон-4. Өмнөх дурсгалын баруун талд 100 м орчим зайд байрлана. Овгор шорооны дээр 1 ш том хэмжээтэй нимгэн хавтгай чулуу байна. Тус хашлага чулуу баруун тал руугаа налж унасан. Хашлага чулууны гадаргад хээ чимэглэл мэдэгдэхгүй ажээ. Хэмжээ нь 140 x 68 см.

Номгон-5. «Номгон-4» дурсгалын хойд талд 200 м орчим зайд Их номгоны хөндийн хойд захад байрлана. 37 x 37 м хэмжээтэй тэгш өнцөгт хэлбэртэй шороон хэрэмтэй байгууламж байна. Хэрмийн зузаан 4.1м юм. Хэрмийн дотор баруун урд болон баруун хойд буланд дөрвөлжин тахилын хавтантай. Хойд талд байрлах тахилын хавтангийн харалдаа, суугаа хүн чулуу бий. Хэрмийн төв хэсэгт хонины хөшөө байна. Мөн хэрмийн дотор талын зүүн захад унасан хүн чулуу байрлана. Баруун хойд булангийн тахилын хавтан чулууны зүүн хашлагыг голлуулан суугаа хүн чулуу босгосон ажээ. Тус байгууламжийн хэмжээ 280 x 286 см. Зүүн талд 110 x 12 см хэмжээтэй хашлага чулуу газраас дээш 5 см цухуйж мэдэгдэнэ. Тахилын урд талаар жижиг чигжээс чулуу мэдэгдэнэ. Хашлага чулуу мэдэгдэхгүй. Тахилын хавтангийн хойд талын хашлага чулуу 160 x 22 см хэмжээтэй юм. Хоёр дугаар тахилын хавтангийн зүүн болон урд талын хашлага чулуу мэдэгдэнэ. Зүүн талын хашлага чулуу 90 x 10 см хэмжээтэй ба газраас дээш 5 см ил гарсан. Урд талын хашлага



Зураг 2. «Номгон-2» тахилын онгон цогцолборын малтлагаас өмнөх дроны зураг.

чулуу 190 x 12 см хэмжээтэй. Газраас дээш 26 см цухуйсан буй. Баруун болон хойд талын хашлага чулуу байхгүй боловч хавтангийн гадна талын чигжээс чулуу мэдэгдэнэ. Хэрмийн үүд болон гадна талд зэл чулуу мэдэгдэхгүй байна.

Номгон-6. «Номгон-5» дурсгалын зүүн талд 500 м орчим зайд байрлана. Дөрвөлжин шороон хэрэмтэй. Хэрмийн хэмжээ 44 x 38 м ажээ. Хэрмийн зузаан 7.3 м юм. Хэрмийн дотор баруун захад 2 ш тахилын хавтан мэдэгдэнэ. Мөн хэрмийн дотор баруун, зүүн хойд, зүүн хэсгүүдэд овгор шороон байгууламжууд бий. Хэрмийн гадна талын урд хэсэгт хэрэмтэй залгаа өндөр овгор шороон байгууламж байна. Хэрмийн хаалга мэдэгдэхгүй ажээ. Хэрмийн зүүн талд гурван эгнээ зэл чулуу зүүн зүгт 40 м орчим зайд үргэлжилнэ. Хойд захын зэл чулуу 6 ш, дунд эгнээний зэл чулуу 11 ш, урд эгнээний зэл чулуу 4 ш үлдсэн ба эдгээр нь бүгд унасан.

Номгон-7. «Номгон-6» дурсгалаас хойд зүгт 700 м орчим зайд Бага номгоны урд дэнжид байрлах айлын зүүн талд 100 м орчим зайтай байрлана. Дөрвөлжин хэлбэртэй овгор байгууламж байна. Хэмжээ нь 21 x 22.5 м. Гадаргад битүү дэрс ургасан. Овгор байгууламжийн гадна талын хойд болон зүүн талаар ялимгүй хонхор ажиглагдана. Энэ нь байгууламжийг тойруулан бэлтгэсэн шуудууны үлдэгдэл байж болох талтай. Тус байгууламж нь гол хэсэгтээ тахилын 1 ш хавтантай. Хавтангийн зүүн баруун талын хашлага чулууны гадаргад ханан хээ сийлсэн байна. Тахилын хавтан 230 x 290 см хэмжээтэй. Зүүн талын хашлагыг 220 x 13 см хэмжээтэй нарийн ширхэгтэй цагаан саарал боржин чулууг өнгөлөн засаж гадна талд нь ханан хээ сийлж хийсэн байна. Тус хашлага өнгөн хөрснөөс дээш 52 см ил байна. Урд хашлагыг 124 x 14 см хэмжээтэй нимгэн хавтгай боржин чулуу ашиглан бэлтгэсэн. Өнгөн хөрснөөс дээш 28 см цухуйсан ажээ. Баруун талын хашлага чулуу 180 x 13 см хэмжээтэй ба өнгөн хөрснөөс дээш 62 см ил байна. Хойд хашлага чулуу 155 x 13 см хэмжээтэй ба өнгөн хөрснөөс дээш 10 см цухуйсан. Тахилын

хавтангийн гадна талаар ил мэдэгдэх хөшөө чулуугүй

Номгон-8. «Номгон-7» дурсгалаа хойд зүгт 400 м орчим зайд 4 ш хөшөө чулууг бөөгнүүлэн нэг дор нь тавьсан байна.

Номгон-9. Өмнөх дурсгалын хойд талд 50 м орчим зайд байрлана. Битүү дэрс ургасан овгор шороон байгууламж байна. Байгууламжийн гадна талаар шороон хэрэм бололтой зүйл ажиглагдана. Хэмжээ нь 26 х 22.5 м. Хэрмийн ханын зузаан 5 м юм. Голын овгор байгууламжийн төв хэсэгт 1 ш тахилын хавтан бий. Хэмжээ нь 240 х 252 см. Тахилын хавтангийн дөрвөн буланд нарийн ширхэгтэй цагаан саарал боржин чулууг ховил гарган засаж ховилд хашлага чулууг шургуулан хийж бэлтгэж байжээ. Тахилын хавтангийн зүүн хойд булангийн ховилтой босоо чулуу байхгүй байна. Хавтангийн баруун талын хашлага чулуу үлдсэн ба бусад хашлага чулуу устаж үгүй болжээ. Үлдсэн хашлага чулуу гадна талдаа ханан хээ сийлсэн байна. Хашлага чулуу 211 х 11 см хэмжээтэй ба өнгөн хөрснөөс дээш 40 см цухуйсан. Тахилын хавтангийн дотор талд булагдсан нарийн ширхэгтэй шаргал боржин чулуугаар урласан хүн чулуун хөшөө цухуйж байна. Хэмжээ нь урт нь 57 см, өргөн нь 20 см. Зүүн урд булангийн ховилтой боржин чулуу 58 х 30 х 18 см хэмжээтэй. Ховил нь 10 х 8 см. Баруун урд булангийн ховилтой боржин чулуу 65 х 32 х 32 см, ховил 10 х 8 см хэмжээтэй. Баруун хойд булангийн ховилтой боржин чулуу 62 х 28 х 28 см, ховил 10 х 9 см хэмжээтэй.

Археологийн малтлага судалгаа: Хоёр улсын хамтарсан экспедиц нь “Номгон”-ы хөндийн цогцолбор дурсгалуудын бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлох, нарийвчилсан тодорхойлолтын үйлдэх, археологийн томоохон цогцолбор дурсгалт газарт малтлага хийх, он цагийг тогтоох, эртний түрэгийн зан үйлийн цогцолбор дурсгалуудын түүх, соёлын ач холбогдлыг шинжлэх зорилготой судалгааны ажлаа эхлүүлэв. Ийнхүү судалгааны ажлын явцад хожуу Түрэгийн хаант улсын үеийн 9 тахилын онгон бүхий цогцолбор дурсгалт газруудыг нарийвчилсан бүртгэн баримтжуулалт хийсний үндсэн дээр хааны тахилын онгон цогцолбор дурсгалт газруудад тохиолддог шоо чулуу бүхий «Номгон-2» дурсгалт газрыг сонгон археологийн малтлага судалгааны ажлаа эхлүүлсэн юм.

Хамтарсан экспедиц нь «Номгон-2» тахлын онгон цогцолбор археологийн малтлага, хайгуул үйлдэх, түүхэн-харьцуулсан, соёлын давхарга зүй, байрлал зүй, зураг зүй, харьцуулсан-типологийн, бичгийн эх сурвалжийн сэргээлт зэрэг аргыг өргөн ашигласан. Малтлагыг гэрэл зураг, гар зургаан баримтжуулсан. Мөн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан 100-400 м-ийн өндөрт


дреноор агаараас гэрэл зураг, видео бичлэг хийсэн юм. Малтлагаас олдсон малын ясыг радиокарбоны шинжилгээнд илгээсэн болно. Эртний түрэг, согд, брахми, бярман бичээсийг бичих зүйн үүднээс харьцуулах аргыг ашигласан болно.

2019 оны археологийн малтлага судалгаа: Археологийн малтлага хийхээс өмнө тахилын онгон бүхий цогцолбор дурсгалт газарт хүн, хуц чулуун хөшөө хадгалагдаж байсан нь мэдэгдэж байсан. Баруунаас зүүн тийш зууван хэлбэртэй уг цогцолборыг тал бүрээс нь шуудуу шиг ухаж, хөрсийг нь овоолж цайз болгосон ажээ. Үүний зэрэгцээ тус цогцолбор дурсгал нь өмнө нь битүү хаалга, дээвэртэй барилга байсан нь байгууламжийн гадуур тархсан тоосгоны хэлтэрхий, шавар ваарны хагархайн үлдэгдэлээс тодорхой харагдаж байв. Цогцолбор дурсгалын баруун талд голдоо нүхтэй том дөрвөлжин шоо чулуу (тахилын чулуу) бий. Цогцолборын гаднах хүрээ нь хөх саарал боржин чулуугаар хийсэн балбалаар хүрээлэгдсэн. Одоогийн байдлаар гадаргуу дээрх балбалын тоо 11 ширхэг мэдэгдэнэ. Тахилын онгон бүхий цогцолбор дурсгалын хаалганы зүүн талд 47 ш зэл (балбал) чулуутай. Бүх зэл чулууд хэвтээ байдалтай байна. Зэл чулуудын зарим нь газарт булагдсан, хугарсан, зарим чулууны зөвхөн ирмэг харагдана. Эдгээр зэл чулуудын хоёрт нь «Эшир» (“ашина”) [Мөнхтулга 2019: 633-637] хааны овгийн тамгатай болох нь тогтоогдсон. Үүнээс гадна янз бүрийн ваарны хагархай болон барилгын бусад олдвор олдсон юм [Кыдырали., нар 2019: 80; Цэвээндорж нар. 2019: 45].

Энэхүү цогцолбор дурсгал 50 метр урт, 40 метр өргөн хэмжээтэй. Байгууламжийн гадна талаар дөрвөлжин хэрмийн үлдэгдэл мэдэгдэнэ. Хэрмийн гадна талаар бага зэргийн хонхор хайрган хөрс ажиглагдана. Түүний гадна талаар дөрвөлжин хэлбэртэй овгор шороон байгууламж үл ялиг мэдэгдэх ба зарим газраа өнгөн хөрсөнд уусан тэгш харагдах ажээ. Энэ нь тус байгууламж давхар хэрэм болон далантай байгаад хожим газар тариалангийн явцад тэгшлэн засагдсан байж болох талтай юм. Гадна далангийн хэмжээ 50 х 45 м. Дотор хэрэм 46 х 38 м хэмжээтэй хэрмийн зузаан 4.5 м. Хэрмийн дотор талд зүүн зүгт 1200 чиглэлтэй зууван уртавтар овгор шороон байгууламж мэдэгдэнэ. Тус байгууламжийн баруун тал харьцангуй цул тэгш овгор бол зүүн хэсэг урд захаараа хагас саран хэлбэртэй овойж тогтсон бүтэцтэй. Голын овгор байгууламжийн баруун хэсэгт нарийн ширхэгтэй, голдоо дугуй нүхтэй дөрвөлжин саарал боржин чулуу хойд тал руугаа налуу байрлалтай байна. Тус дөрвөлжин чулууны хойд үзүүр шороонд шигдэж орсон ажээ. Хэмжээ нь 220 х 220 см, зузаан 33 см юм.



Зураг 3. Күлтэгийн тахилын онгон цогцолборын тахилын чулуу



Зураг 4. Билгэ хааны тахилын онгон цогцолборын тахилын чулуу



Зураг 5. «Номгон-2» тахилын онгон цогцолборын тахилын чулуу

Голын дугуй нүхний амсарт давхар төвгөр хөмсөг гаргасан. Гадна талын дугуй төвгөр хүрээ 113 см, дотор талын төвгөр дугуй хүрээ 82 см бол голын нүхний голч 67 см хэмжээтэй. Энэхүү чулууны зүүн хойд талд бүдүүн ширхэгтэй дөрвөлжин хэлбэртэй боржин чулуу ил мэдэгдэнэ. Энэ нь хөшөө чулууны хугархай байж болох талтай. Голын овгор шороон байгууламжийн зүүн үзүүрийг хагас дугуйрсан овгорын дунд хэсэгт

бүдүүн ширхэгтэй шаргал боржин чулуугаар бэлтгэсэн толгойгүй хонины хөшөө ил мэдэгдэнэ. Байгууламжийн хэрмийн гадна талыг тойрсон зэл чулуутай. Хэрмийн үүд зүүн зүгт харсан, 6.4 м хэмжээтэй. Хэрмийн үүднээс зүүн зүгт 1200 чиглэлтэй 47 ш зэл чулуу 200 м орчим зайд үргэлжилнэ.

Бид байгууламжийг гадна талын хэрмийн гадуур 50 x 50 м хэмжээтэй хүрээ татаж 4 x 4

м өрөгт хувааж малтлага судалгааг эхлүүлэв. Ингэхдээ энэ жил дурсгалыг бүрэн малтаж амжихгүйн улмаас тухайн байгууламжийн бүтэц зохион байгуулалтыг нарийвчлан судлах үүднээс уртраг болон өргөргийн тэнхлэгийн дагуу 1 м өргөн хамар үлдээж өрөгт хуваасны дагуу транш татан малтав. Өргийн хойд болон зүүн хэсэгт 50 см өргөн хамар үлдээж малтлагын ажлыг босоо тэнхлэгийн J6, хөндлөн тэнхлэгийн 6 өргийн дагуу зүсэлт хийх замаар эхлүүлсэн.

Малтлагын 1-р үед 5-10 см гүнд өнгөн хөрсийг хуулахад захаар буюу AJR. Өргүүдэд жижиг хайрган хөрс мэдэгдэнэ. Өрөг J11 талбайн гол хэсэгт дугуй нүхтэй чулууны хажууд босоо тэнхлэгийн хананаас урд зүгт 110 см, өргийн баруун ханаас зүүн зүгт 30 см зайд дээврийн ваарын үлдэгдэл 12 см гүнээс олдсон. Эл олдворын хойд талд босоо тэнхлэгээс урд зүгт 30 см, өргийн баруун ханаас 107 см зайд бүдүүн ширхэгтэй хөх тоосгоны хагархай 10 см гүнээс гарч байв. Мөн өргийн зүүн хойд буланд 11 см гүнээс дээврийн ваарын хагархай 1 ш илэрсэн. Өрөг G7 - ийн баруун захаар 120 см өргөн дагтаршуулсан хөрс 10 см гүнд мэдэгдэнэ. Бусад хэсэгт төдийлөн сайн хөрсний ялгарал ажиглагдахгүй байна. Зөөлөн хүрэн бор хөрс мэдэгдэнэ. Тиймээс малтлагын талбайг гэрэл зургаар баримтжуулалт хийж дараагийн үеийг эхлүүлэв.

2-р үе: Хөрсний ялгарал сайн мэдэгдэхгүй ба өмнөх бор хөрс үргэлжилж байсан тул малтлагыг 20 см гүнд үргэлжлүүлэв. Малтлагын явцад G4, G5 болон G6 - өргөөс 36 см гүнээс дээврийн ваарын хагархайнууд их хэмжээгээр илэрсэн. G4 - р өргийн баруун хойд буланд болон G5 өргийн зүүн хойд буланд нягтрал ихтэй. G7 - р өргийн дагтаршуулсан хөрс үргэлжлэх ба малтлагын явцад гол хэсэгт зөөлөрч буй явдал нь тонуулчдын ухсан нүхний шороо дагтаршиж хана мэт давхаргыг үүсгэсэн бололтой юм. Тус хайрган хөрс хөндлөн тэнхлэгийн дагуух F7 - р өрөгт 46 см үргэлжлэх ба хайрга болон цагаан шаргал шаварлаг хөрстэй холилдсон тогтсоноороо онцлог юм. Тиймээс эл хатуу хөрсөн давхаргууд бол ямар нэг байгууламжийн хана бус тонолтын явцад бий болж дагтаршсан хөрс гэж үзэж болохоор байна. Байгууламжийн хэрмийн хойд хэсэг буюу хөндлөн тэнхлэгийн дагуу B7 - р өрөгт жижиг хайрган чулуу бүхий хөрс ажиглагдана. Малтлагын талбайг гэрэл зургаар баримтжуулалт хийв.

3-р үе: Талбайн хэмжээг багасган босоо тэнхлэгийн дагуу 1 м өргөн хэмжээтэй малтлагыг ажлыг үргэлжлүүлэв. Малтах явцад G4 - р өргийн зүүн хойд булангаас 53 см гүнээс хүний хөлийн шилбэний яс, боржин чулууны хагархай, дээврийн ваарын үлдэгдэл олдсон. Мөн G5 - р өргийн зүүн

хойд буланд босоо тэнхлэгийн хананаас урд зүгт 30 см, өргийн зүүн хананаас баруун зүгт 60 см зайд 32 см гүнээс дээврийн ваарын хагархайнууд болон боржин чулууны хагархай илэрч байв. G6-р өргийн А хэсэг буюу малтлагын талбайн баруун хойд булангаас 38 см гүнээс бог малын далны толгойн яс, дээврийн ваарын хагархай их хэмжээгээр олдож байв. Олдворуудыг гэрэл зургаар баримтжуулалт хийж малтлагын ажлыг үргэлжлүүлэхэд J6-р өргийн С хэсэг буюу зүүн урд булангаас 90.5 см гүнд малын яс илэрсэн юм. Малтлагын ажлыг үргэлжлүүлэхэд G8 - р өргийн зүүн хойд талын боржин чулуун хонины хөшөөний хажуугаас боржин чулууны хагархай, ваарын хагархай хэлтэрхийнүүд илэрч олдож байв. Боржин чулууны хагархайнуудын нэг нь хонины толгойн хэсэгт эвлэх ба нэг хажууд хагас саран хэлбэртэй төвийлгөн сийлсэн дүрстэй. Энэ нь тухайн чулуу хонины толгойн хэсгийг болохыг илэрхийлэхээс гадна, саран хэлбэрийн дүрс нь хонины эвэрний дүрс ажээ.

Саарал өнгөтэй нягтрал сайтай дээврийн ваарын хагархайнууд J6, H6 - р өргүүдээс 25 см гүнд цөөн тоотой олдсон юм. Илэрсэн олдворуудыг гэрэл зургаар баримтжуулалт хийж дараагийн үеийг эхлүүлсэн.

4-р үе. G8, G9-р өргүүдэд 20 см гүнд малтлагыг үргэлжлүүлсэн ба G8 - р өргөөс боржин чулууны хагархай, нүүр ваарын хагархай цөөн тоотой олдсон ба дээврийн ваарын хагархай их хэмжээгээр гарч байв. Ваарын хагархайн тархцын нуранги тус өрөгт шигүү тархацтай байна. Энэ нь голын тахилын сүмийн зүүн захыг харуулж байна. Мөн G9 - р өргөөс боржин чулууны хагархай болон цөөн тооны дээврийн ваарын хагархай 45 см гүнд олдсон. Олдворыг гэрэл зургаар баримтжуулалт хийсэн.

5-р үе. G8 - р өргийн малтлагыг 10 см гүнд үргэлжлүүлэн малтав. Малтах явцад 55 см гүнд дээврийн ваарын хагархай шигүү тархацтай илрэв. Мөн арслангийн хөшөөний хойд талд урд хананаас 20 см зайд 55 см гүнд дугуй хэлбэртэй нүүр ваар олдсон нь содон дүрслэлтэй юм. Энэхүү нүүр ваар саарал өнгөтэй, нягтрал сайтай гадаргын зах хөвөөгөөр төвгөр хүрээ гаргаж голд нь инээж буй хүний дүрс гарган цутгаж бэлтгэсэн өвөрмөц дүрслэлтэй юм. 23 x 15 x 1.1 см хэмжээтэй.

Арслангийн хөшөө. Саарал өнгөтэй боржин чулууг түүхий эд болгон бэлтгэсэн.

Арагш мөлүү чих болон төвгөр нарийн хөмсөгтэй бүлтгэр нүд, шулуун өндөр хамартай арсланг хойд хоёр хөл дээрээ оцойж суусан байдалтай дүрсэлсэн. Бахим өргөн эрүү болон үзүүр хэсэгтээ нарийссан урт сахалтай.

Хүзүүндээ олон салаалж эргэсэн зогдортой. Цээжин хэсэг урагш төвгөр. Тус арслан сүүлээ ар



Зураг 6. Билэг хааны тахилын цогцолборын арслан чулуун хөшөө

зоон дээгүүр давуулан шидсэн байна. Арслангийн хэвлийн харалдаа урагш болон ар тийш цавь руу нь харсан хоёр гүегийг сийлсэн байна. Урд талын баруун хөлөө дээш өргөн сагалгаагаараа нугалж хоёр гүегээ өөр лүгээ налуулсан байдалтайгаар дүрсэлжээ. Ингэхдээ гүегүүд бие биен дээрээ давхарласан байдалтай дүрсэлсэн. Эхний гүег эхийнхээ хэвлийд нэвт шургасан ба толгойг эхийн цавины харалдаа гаргаж бөгсөн биеийг хэвлийн харалдаа гаргаж дүрсэлсэн бол удаах гүегийн эхний гүегийн ар талаас зүүн дээгүүр гарч ирж буй байдалтай урд хоёр хөл болон толгойг мэдэгдэхүйц тодоор сийлбэрлэсэн байна.

Хонины хөшөө. Бүдүүн ширхэгтэй шаргал боржин чулуугаар бэлтгэсэн ажээ. Хөшөө чулууны толгой ташуулдан тайрагдсан ажээ. Хөшөө чулууны хоёр хажууд хэлбэр дүрс нь тодорхойгүй угалзарсан бүдэг сийлбэр мэдэгдэнэ. Энэ нь хонины доод мөчдийг сийлсэн нь он цагийн эрхэн бүдэрч мэдэгдэх төдий болсон гэлтэй. Зүүн хэсэг нь хоггор нумарсан хэлбэртэй. Сүүлний дүрслэл мэдэгдэхгүй.

Зэл чулуун дахь хааны овгийн «Эшир» (ашина) тамганууд. «Номгон-2» тахилын онгон цогцолборт 48 ширхэг балбал чулуун цуваа зүүн тийш цувран эгнэсэн.

2019 онд хамтарсан экспедицийн малтлагын үеэр 1-р, 15-р балбал чулуун дээрээс «эшир» (ашина) хааны овгийн тамга олдсон юм [Цэвээндорж нар. 2019: 45].

2022 оны археологийн малтлагын үеэр өөр нэг балбал олдсон. Энэ бол балбал мэлхий чулуун суурийн олдсон салбараас гарсан том балбал чулуу юм. Энэ бол цогцолборын хамгийн том бөгөөд анхны балбал юм. Балбал дээр «Эшир» (ашина) хааны овгийн тамгыг томоор сийлсэн байна.

Ийнхүү цогцолборын балбалын тоо нь 48 болж байна. Дээр дурдсан 1-5-р балбал, 16-р балбалын малтлагын явцад «Эшир» (Ашина) хааны овгийн



Зураг 7. «Номгон-2» тахилын цогцолборын хоёр гүегтэй арслан чулуун хөшөө

тамганууд шинээр олдсон юм. Харин 20-р балбал дээр саран тамга сийлсэн байна.

2022 оны археологийн малтлага судалгаа: 2022 оны малтлагын ажил нь 2019 онд булан хамгаалсан өргүүдийг цэвэрлэснээр эхэлсэн билээ. Булсан хөрсийг цэвэрлэж, малтлага хийх газрыг цааш нь хучилттай болгосон. Өргүүдийн дарааллын дагуу газар шорооны малтлагын ажил эхэлсэн билээ. Археологийн шинжлэх ухаанд туршигдсан аргуудын нэг болох хамар үлдээн малтсанаар, Тахилын сүмийн байгууламжаас унасан шавар эдлэл, шороон овоолгын зүсэлт (профиль), соёлын давхарга нь тодорхой болсон юм. Үүний тулд байгууламжийн баруун, зүүн, арын хэсгээс хөндлөн огтлолыг үлдээж, гэрэл зураг, гар зураг үйлдсэн.

2022 оны малтлагын үеэр онгон цогцолборын нийт хэмжээ, гаднах хүрээ, хэрэм, цайз, хаалга зэрэг архитектурын цогц байгууламжийг нь илрүүлсэн. Цогцолборын нийт хэмжээ 49 x 41.5



Зураг 8. Балбал №1 тамга



Зураг 9. Балбал №2 тамга



Зураг 10. Балбал №3 тамга



Зураг 11. Балбал №4 тамга



Зураг 12. Балбал №5 тамга



Зураг 13. Балбал №16 тамга

метр талбайг хамарсан. Баруунаас зүүн тийш сунаж тогтсон цогцолборын эргэн тойронд шуудуу ухаж, хөрсийг нь овоолж цайз хийсэн нь мэдэгдэж байна. Гаднах периметр нь цэнхэр боржин чулуун хашлагаар хүрээлэгдсэн байдаг. Цогцолборын баруун талд голдоо нэвт нүхтэй том дөрвөлжин шоо тахилын чулуу [Кыдырالي нар. 2019: 80] бий. Тахилын чулууны доорх дөрвөлжин чулуун тавцангийн дөрвөн буланг тодорхойлж хэмжилт хийсэн. Дөрвөн өнцөгт тавцангийн урт нь 160 см, өргөн нь 80 см, зузаан нь 14 см болно.

Үүний зэрэгцээ тахилын сүмийн барилга байгууламжийн оройноос унаж тархсан шавар

дээврийн болон нүүр ваар, шороон овоонуудыг цэвэрлэж, байгууламжийн хэлбэр, хэмжээг тодорхойлсон. Байгууламжийн ханыг нь шороогоор чигжиж хийсэн бөгөөд будсан шохойн үлдэгдэл тодорхой харагдана. Байгууламжийн дээврийг бүрхсэн шавар ваар нь цэвэр шавраар хийгдсэн бөгөөд маш баг бөх юм. Үүний тулд шавар эдлэлийг дугуй хэлбэртэй модон хэвд цутгаж, хэвээс нь гарсны дараа тусгай зууханд шатааж боловсруулдаг ажээ. Дээврийн ваарын дотор талд хэвд байрлуулсан давууны ул мөр тодорхой харагдаж байна. Сайтар хадгалагдаж үлдсэн шавар ваарын урт (хавтанцар) нь 34 см, өргөн нь 13.5 см, зузаан нь 1.8 см.

Шалны тоосгоны гаргаж хаяснаас байгууламжийн дотор талыг нь тонон дээрэмдсэн нь тодорхой мэдэгдэнэ. Хаа сайгүй эвдэрсэн хугархай тоосго олон бий. Тоосго нь нутгийн шар шавартай хайрган шороог тусгай хэвд хийж, шатаан хийсэн бололтой. Хадгалсан тоосгоны хэмжээ нь 33 см урт, 17.5 см өргөн, 6.8 см зузаантай.

Хааны хүн чулуун хөшөө нь анх байгууламжийн дотор байсан байж магадгүй. Хожим нь тонуулчид барилгыг сүйтгэхдээ чулуун хөшөөг ч мөн адил цогцолборын баруун талд гаргасан бололтой юм. Хааны хүн чулуу завиран суусан дүрслэлтэй байна. Тэр бүсэлхийнээс дээш хугарсан, зүүн гараа өвдөг дээрээ тавьсан байдалтай.

Түүнчлэн тус цогцолборт тахилын сүм бүхий байгууламж байсныг илтгэх, явган хүний зам дээр тавьсан шавар хавтан, тоосгоны үлдэгдэл олдсон юм. Цогцолборын баруун талд дундаа нэвт нүхтэй шоо хэлбэртэй тахилын чулуу, хүн чулуун хөшөө, хажууд нь хоёр гүегтэй арслангийн чулуун хөшөө, хоёр хуц хонины чулуун хөшөө олдсон билээ. Цогцолборын хаалганы зүүн талд 48 балбал зэл чулуун цуваа бий.

Эдгээрээс зургаан балбал дээр овгийн «Эшир» (Ашина) хааны овогт хамаарах «янбир» тамгатай болохыг малтлагын явцаар илрүүлсэн.

Цогцолбор дурсгалд нийтдээ 6 хүн чулуун хөшөө байсан байна. Хоёр хүн чулуун хөшөөний зөвхөн доод хэсэг нь хадгалагдан үлджээ. Тэд анхны байрандаа байна. Үлдсэн чулуун хөшөөд нь энд тэнд бутран хугарсан хэлбэрээр өөр өөр сектороос олдсон юм.

Хуц чулуун хөшөөний толгойн хугарсан, үлдсэн хэсэг нь сайн хадгалагдан үлдсэн. Бүх чулуун хөшөө нь цайвар өнгийн бүдүүн ширхэгтэй боржин чулуугаар сийлэн хийгдсэн байна.

Ер нь малтлагын явцад боловсруулсан дугуй

хэлбэртэй чулуун эдлэл, модны үлдэгдэл, адуу, хонины яс, шатаасан тахилын үлдэц ором газрууд олдсон. Шинээр олдсон бүх олдворын гэрэл зураг, гар зураг хийгдсэн, зарим дурсгалын цаасан хуулбар хэвийг авч, баримтжуулалт үйлдсэн болно.

Хааны чулуун хөшөөний толгойн хэсэг

Хөшөөний толгойг цайвар өнгийн том ширхэгтэй боржин чулуугаар хийсэн. Уран барималч нь угсаа, нийгэм, насны онцлогтой хүний бодит дүр төрхийг харуулсан юм. Хөшөөн дээр дунд эргэм насны эрэгтэй хүний дүрс тод харагддаг.

Толгойн баримал нь Күлтегиний чулуун хөшөөний толгойтой төстэй малгайны загварыг дүрсэлсэн байна [Jisl 1960: 86-115; Сэр-Оджав 1979: 8]. Толгойн хувцас нь таван салаа бүхий титэм бүхий хэлбэртэй байна. Толгойн оройноос эхэлсэн зовхи нь гүдгэр болж, хамар хүртэл үргэлжилсэн. Хамар нь дугуй, үзүүр нь дугуй хэлбэртэй байдаг. Нүд нь ялимгүй аниастай, нүүр нь зууван, эрүү нь дугуй хэлбэртэй байна.

Күтлүг хааны гэрэлт хөшөөний бичээсний анхны уншлага:

2022 онд археологийн малтлагын үеэр онгон цогцолборын хаалганы ойролцоо сектороос гэрэлт хөшөөний оройн хэсгийн хагарсан хэсэг нь олдсон. Түүний хэмжээ нь 70x74.5 см, өргөн нь 19 см. Хөшөөний толгойн дээд хэсэг нь хугарсан мэлхий чулууны суурь олдсон юм.

Өөрөөр хэлбэл, гэрэлт хөшөө нь мэлхий чулуун суурьтай болох нь тодорхой мэдэгдэнэ. Мэлхий чулуун суурь нь зүүн зүгт харсан анхны байрлалаасаа тийм ч их өөрчлөгдөөгүй байдалтай байна. Мэлхий чулууны дээд хэсэгт гэрэлт хөшөөг суурилуулах гүн бөгөөд ташуу ховилтой нүхтэй. Мэлхий чулууны урт нь 97.5, өргөн нь 73 см, өндөр нь 41 см юм.

Хамтарсан экспедиц ирэх онд гэрэлт хөшөөний үлдсэн хагархай дунд хэсгийг хайх малтлага судалгааны ажлыг дараа жил үргэлжлүүлнэ.

Гэрэлт хөшөөний тал бүр дээр (бид талуудыг I-IV гэж тэмдэглэв) эртний түрэг (I, II, IV), согд (III), брахми (IV) бичгээр бичээс сийлсэн болох нь мэдэгдэж байна. Судалгааны ажлын урьдчилсан үр дүнгээс харахад гэрэлт хөшөөний II гадаргын 19 мөр бичээсээс 12 мөр нь илүү сайн хадгалагдсан болох нь мэдэгдэж байна. Бичээсийн зарим үсгийг уншихад хэтэрхий бүдэг баларсан тул цаашид дахин нягтлах шаардлагатай юм. Эртний түрэг хэл дээрх бичээсийн үг, үг хэллэгийг ялгах цэг таслал нь гурав цэгтэй байгаа нь онцгой анхаарал татаж байна. Энэ гэрэлт хөшөөний эртний түрэг бичгийн тамга - тэмдэгт бичвэрийн үсгүүд нь



Зураг 14. «Номгон-2» тахилын онгон цогцолбороос олдсон малгайтай хүн чулууны толгойн хэсэг



Зураг 15. Күлтэгийн толгойн хэсэг. Анхны гэрэл зураг (Чехословак-Монголын археологийн хамтарсан экспедиц, 1958 он.)




Зураг 16. Хааны дүрслэлтэй чулуун хөшөөний доод хэсэг



Зураг 17. Күлтэгийн чулуун хөшөөний доод хэсэг. Анхны гэрэл зураг
(Чехословак-Монголын археологийн хамтарсан экспедиц, 1958 он.)



Зураг 18. «Номгон-2» тахилын онгон цогцолбор. Гэрэлт хөшөөний оройн хэсэг




Зураг 19. «Номгон-2» тахилын онгон цогцолбор. Гэрэлт хөшөөний цаасан дардас хуулбарт үндэслэсэн сэргээлт



Зураг 20. «Номгон-2» тахилын онгон цогцолбор. Гэрэлт хөшөөний бичээсний I тал. Бичээс нь баларсан байдал.



Зураг 21. «Номгон-2» тахилын онгон цогцолбор. Гэрэлт хөшөөний бичээсний IV, IV-1 тал. Брахми бичээсний хэсэг болон үсэг бичиг баларсан байдал




Зураг 22. «Номгон-2» тахилын онгон цогцолбор. Гэрэлт хөшөөний бичээсний II тал. Эртний түрэг бичээсийн хэсэг болон үсэг бичиг баларсан байдал



Зураг 23. «Номгон-2» тахилын онгон цогцолбор. Гэрэлт хөшөөний бичээсний II тал. Эртний түрэг бичээсийн цаасан хуулбарт үндэслэн сэргээсэн зураг




Зураг 24. «Номгон-2» тахилын онгон цогцолбор. Гэрэлт хөшөөний бичээсний III тал. Эртний согд бичээсний хэсэг болон үсэг бичиг баларсан байдал.



Зураг 25. «Номгон-2» тахилын онгон цогцолбор. Гэрэлт хөшөөний бичээсний III тал. Эртний согд бичээсний цаасан хуулбарт үндэслэн сэргээсэн зураг



Зураг 26. «Номгон-2» тахилын онгон цогцолбор. Гэрэлт хөшөөний бичээсийн IV-1 тал. Эртний брахми бичээсийн хэсэг болон үсэг бичиг баларсан байдал



Зураг 27. «Номгон-2» тахилын онгон цогцолбор. Гэрэлт хөшөөний бичээсийн IV-1 тал. Эртний брахми бичээсийн цасан хуулбарт үндэслэн сэргээсэн зураг



Зураг 28. «Номгон-2» тахилын онгон цогцолбор. Малтлагаар илрүүлсэн мэлхий чулуун суурь

<i>Кутлук хааны гэрэлт хөшөөний бичээсний анхны уншлага</i>			
Гэрэлт хөшөөний бичээснүүд			
Талууд	Мөр		Монгол хэлээр
I	Эртний	түрэг хэлний галиглал	
		?	
		?	
		?	
	...?	?	
II	Эртний	түрэг хэлний галиглал	
		ud yil: toqzunč: ay: [y.....]	Үхэр жил: есдүгээр сар
		[al]tim: ü[mü]n: üčünčü [k.....]	Авлаа би:гутгаар
		almiš:Teḡri: oylu: [.....]	Авсан ажээ: Тэнгэр: хүү.....
		[Q]utluḡ qaḡan: TÜRÜK [.....]	Кутлук хаан : Түрэг.....
		ur oylum: yüz yüz [.....]	Эр хөвгүүн минь: зуу зуу.....
		biziḡ:öḡlüḡ: [k.....]	Бидний: өнгөт.....
		itdim: bizi: yat er: [.....]	үйлдэв: биднийг: харь: эр.....
		yerde: qa[z].. tuz.....[.....]	газарт: тохинуу-.....
		tümen: tümen: [.....]	түмэн :түмэн.....
		atadim: bin biḡdim [.....]	алдарлай: би..?
		isig :küčüg: ber[.....]	хэргийг :хүчийг: өгөх-....
		es[?] :qop ešti [.....]	ухаан: олонтоо сонсов.....
	13-19
III	Эртний	согд хэлний галиглал	
		
		Qutlug x'g'n	Хутлуг хаган
		
		
		
		tti.....	
IV	Эртний	түрэг хэлний галиглал	
		?	
		?	
		?	
	...?	?	
IV-1	Эртний	брахми үсэг хэлний галиглал	
	1	?	
	2	?	
	3	?	
	...?	?	

«Чойр», «Эл этмиш ябгу» (Онгийн), Күли-чур зэрэг гэрэлт хөшөөний бичээс дээрх эртний түрэг бичгийн тамга - тэмдэгт үсэгтэй тун ч төстэй байгаа билээ. Тийм учраас эртний түрэг бичгийн тамга-тэмдэгт үсгийн хэв маягаараа түрэг бичгийн дурсгалуудын дотроос нэлээд эртнийх нь гэж хэлж болох юм. Мөнхүү, гэрэлт хөшөөний “Согд” бичээсийн үсгүүд нь уншигдахаар хадгалагдсан байна. Брахми бичээс танихын аргагүй болтол баларсан ажээ. Брахми бичээстэй байгаа нь бас их сонирхолтой эх сурвалж төдийгүй эртний руни бичгийн дурсгал болохыг бататгаж байж мэдэх юм. Гэрэлт хөшөөний бүх хэл, бичгээр сийлэн бичсэн бичээснүүдийн өгүүлбэр нь төгсөөгүй, бүрэн бус байгааг анхаарах хэрэгтэй. Дараагийн малтлага судалгааны явцад хөшөө чулууны үлдэгдэл хэсэг олдож бүрэн эхээр нь тайлан унших боломж олдоно хэмээн найдаж байна.

Хэлэлцүүлэг

ШУА-ийн, Археологийн хүрээлэн, Казахстан улс дахь “Олон Улсын Түрэгийн Академи”-ийн хамтарсан «Номгон-2» төслийн 2019, 2022 оны археологийн малтлага судалгааны явцад шинээр олон төрлийн олвор илэрч олдсон бөгөөд тэдгээр нь тухайн цогоцолбор дурсгалын он цагийг баримжаалан тогтоох чухал хэрэглэгдэхүүн болж байна. Дурсгалт газраас илэрсэн олдворууд нь эртний түрэгийн тахилын онгон цогцолбор дурсгалуудад байдаг бусад ижил төрлийн олдворуудтай адил байгаа явдал нь он цаг харилцан хамаарлын хувьд нэг цаг үеийн зан үйлийг харуулна. Гэвч бусад олвор хэрэглэгдэхүүнээс гадна эртний түрэг, согд, брахми бичигтэй гэрэлт хөшөө илэрсэн явдал нь сүүлийн хагас зуун жилийн хугацаан дахь томоохон нээлт болж байгаа юм. Гэвч дээрх тахилын онгон цогцолбор дурсгалыг хэнд зориулагдсан бэ гэдэг зүй ёсны асуулт гарч байгаа хэдий ч бичээс бүхий гэрэл хөшөө илэрч олдсоноор дээрх оньсого мэт таамаглалыг нэ мөр шийдэх боломжийг бидэнд олгож байна. Тус хөшөөний бичээсийн эх бичвэрт үндэслэн уг дурсгал нь *Qutluγ qaγan* Кутлуг (Элтэрис) хаанд зориулагдсан гэж бид дүгнэж болохоор харагдаж байна. Түүхэнд Кутлуг (Элтэрис) хаан гэсэн алдар цол нь зөвхөн 682 оноос дурдагдаж эхэлсэн юм. Кутлуг (Элтэрис)-аас өмнөх хаануудад ийм цол нэртэй хаан огт үгүй билээ. Мөн түүнчилэн, уг гэрэлт хөшөөнд «*ud yil: toquzunč: ay*» үхэр жил: есдүгээр сар» гэж 668, 680, 692, 704 оны аль нэгийг хэлж байгаа нь маш тодорхой мэдэгдэнэ. Дараачийн малтлага судалгааны явцад гэрэлт хөшөөний үлдсэн дунд хэсэг олдвор илэрсэн тохиолдолд дээрх бичээсийн түүхэн үйл явдлын он, сар тодорхой болох юм.

Кутлуг (Элтэрис) хаан төр улсыг төвхнүүлэн Этүгэнд ирсэн хугацааг руни бичгийн болоод хятад бичгийн сурвалжуудад тодорхой заасан байдаг. Гэвч өнөөдрийг хүртэл Кутлуг (Элтэрис) хааны тахилын онгон хаана байдаг талаар тодорхой тогтсон зүйл байхгүй байсан юм. 20, 21-р зууны ихэнх эрдэмтэн санал нэгтгэйгээр Булган аймгийн Баян-Агт сумын нутаг дахь “Шивээт Улаан”-ны дурсгалт газрыг хэмээн үзэж байсан. Гэвч хамтарсан судалгааны төслийн үр дүн болоод түүхэн газар зүйн үүднээс харвал өөр гэдэг нь тодорхой болж байна.

Хятадын сурвалж бичигт: Кутлуг (Элтэрис) хааныг «...Ашина Сели (Сэри) хааны угсааны Гудуло.. бутран доройтсон улс орныг хураан нэгтгэж, Хангай ууланд нутаглан төвлөрч, Каракумын хотноо суурьшиж захиран суув.. Бэлэн цэрэг хүчин 5000.. Тийнхүү цэрэг хүчийг олж, өөрийгөө «хаан» гэж нэрлэв, дүү нэрээ Мочог (Капаганыг) «шад, Дусифуг «ябгу» болгож томилов... Гудулогийн ухаант мэргэн байв. Гудолу түүнийг (Тоникукийг) «апа гархан» болгон томилж бүх цэргийг түүнд захируулав» гэж өгүүлсэн байдаг [Базылхан 2005: 252]. Ер нь эртний түрэг бичгийн дурсгалуудад Кутлуг(Элтэрис) хааны албан ёсны алдар цолыг «*Elteriš qaγan*» Элтэрис хаан» хэмээн алдаршуулан бичсэн байдаг бөгөөд 682-692 оны хооронд хааны ор суусан гэж үздэг. Тэрээр Табгаш (Тан) улсын эсрэг тэмцэлд ялалт байгуулж, Тархан Тоныкук, Капаган, Эл этмиш ябгу (Дусифу) дүү нарын хамтаар бүх нүүдэлчдийг нэг тугийн дор нэгтгэж, хожуу Түрэгийн хаант улсыг байгуулсан түүхтэй.

Тоньюкукийн бичээст “Чугай Кузын Каракумд суух болов бид, ... Огуз (Уйгураас)-аас босуул ирэв. Босуулын үг ийм бөлгөө, Токуз, Огуз иргэн дээрээ хаантай, Табгач руу Кони сангуныг илгээв, Кытан руу Тонра сэм-ийг илгээв. Ийм үг илгээв” Цөөн түрэг зоргоор байх болов... Табгачийг сөнөөнө гэх юм, өмнөх Кытаныг сөнөөнө гэх юм, Миний Огузыг сөнөөнө гэх юм” хэмээн холбоо тогтоохыг оролдож улмаар Тан улс өмнөөс, Кытан зүүнээс, Уйгурын хаан хойд талаас довтлохоор төлөвлөсөн тухай өгүүлсэн байдаг. Уйгур тэргүүт огузуудын төлөвлөгөөг мэдсэн Кутлук, Тоньюкук нар зөвлөлдөж түрүүлж огузуудыг бут цохихоор шийдвэрлэн Тоньюкукт хоёр мянган цэрэг өгч Чугай Кузын Каракумаас давшиж Туул голоос хөдөлсөн Уйгурын зургаан мянган цэрэгтэй шийдвэрлэх тулалдаан хийн ялж тэдгээрийг дагуулав хэмээжээ [Болд, 2010:52-54].

Түүний тухай Күлтегиний гэрэлт хөшөөнд: «... Түрэг түмэн олон нь үгүй болмооргүй сэн гэж, түмэн олон болоосой хэмээн аав минь Кутлуг (Элтэрис) хааныг, эх минь Эл Билгэ хатныг,

Тэнгэр төв дээдээ барин дээш өргөсөн ажгуу. Хаантаан аав минь арван долоон баатар эрийг цуглуулав. Цуглуулан зоримуй хэмээн бүгд (хөвч, бүх) сонсож, балгас дахь нь цугларав, уулан дахь нь буужухуй. Амилан далан эр болжээ. Тэнгэр хүч өгсөн учир (бидэнд) Аав минь хааны сүрт цэрэг нь Бөрт чоно шиг ажээ. Дайсан нь хонь шиг ажээ. Тэнгэр хүч өгсөн учир (бидэнд) Аав минь хааны сүрт цэрэг нь чоно шиг ажээ. Дайсан нь хонь шиг ажээ.Долоон зуун эр болжээ. Долоон зуун эр болжээ...» хэмээн өгүүлдэг билээ.

Кутлуг (Элтэрис) хаан дүү нар болох Капаган, Элетмиш Ябгу (Дусифу) нарын хамт болон мэргэн Тоныкуктай мөр зэрэгцэн 10 жилийн дотор табгаш-хятадуудтай олонтоо тулалдаж, 10 жилийн дотор гарамгай ялалт байгуулжээ. Тэр бээр бүх нүүдэлчидийг хөх тугийн далбаан дор Түрэгийн хаант улсыг сэргээж, улс орноо цуглуулж, төрийн үндсийг бататгаж, хүчирхэг хаант улс, агуу их гүрэн болгож чадсан юм.

Кутлуг(Элтэрис) хааны тухай: «Чойр» -ын хүн чулуунд дээрх (3-р мөрөнд) «Elteris qaγanqa qoñ yil içinç ay jeti-qa adirilmiz- Бид хонин жилийн 3-р сард Элтерис хаганыг алдлаа» гэж бичжээ.

Эл этмиш ябгу гэрэлт хөшөөний бичээст: (11-р мөр): “Элтерис: qaγanqa: adirilmaduq: yañilmaduq: Teñiri: bilge: qaγanta:adirilmalim: azmalim: tejin: ança: ötledim: kerī: barça: ötledim: kerī: barīymī-dun: barī. :bardī: ulugen atqa: esig: küçüg: bertī: - Бид Элтерис хаганыг алдчихлаа, бид андуураагүй, биднийг чадварлаг хаанаас салгаж, ядууруулж болохгүй гэж бурхнаас гуйсан. Бид буцаад нэгдлээ.... Чадварлаг хааны хүмүүс... явлаа. “Хувь заяаны цолонд ажил, хүчээ өгсөн” гэсэн бичвэрүүд бий.

Тоникукийн гэрэлт хөшөөний бичээст (6-7-р мөр): Билгэ :Tuñuquq :Boyla Baγa Tarqan: birle: Elteris qaγan: boluyu: beriye: Tabγaçiy: öñre: Qitañiy:yürīya Oγuziy: üküab:benīiççök: ök: ertim : Çuγay quzīñjin: Qara Qumuγ: olurur: ertimez: - Билгэ Тоныкукийн дагуу бага тархантай нийлэн баруун талд Табгаш, зүүн талд Кидан, зүүн талд Огузыг эзлэв. Би чадварлаг илтгэгч удирдагч мэргэн байлаа. Бид Чугай уулын хар элсэн дээр сууж байсан”, (мөр 50) “Elteris qaγanqa:uçdī: Tūrük Bögü qaγanqa: Tūrük Bilge qaγanqa: ... -Элтэриш хаанд...нисэв. Түрэг Бөгү хаан руу, (61-р мөр) « Elteris qaγan: Bilge Tuñuq-uq : qazyantuq üçün: Qaraγan qaγan: Tūrük Esir budun: yorīdīqī bu – Энд Элтериш хаан, Билигт Тоныкук, эзэмшсэн учир, Капаган хаан, Түрэгийн Эшир хүмүүс тайлбарлав ... “Элтерис Хаантай бүх түүхэн үйл явдлыг тайлбарлав [Қыдырәлі .ред 2020: 368; Қыдырәлі .ред 2022: 125].

Дүгнэлт

Номгоны хөндийн тахилын онгон цогцолбор дурсгалуудын дотроос “Номгон-1. Номгон-2” цогцолбор дурсгалын бүтэц зохион байгуулалт, хэв шинж нь Билгэ хаан, Күлтегин жанжны тахилын онгон цогцолбор дурсгалуудтай ижил юм. Тухайлбал: Номгон гэрэлт хөшөөний оройд хоёр чонын толгойг дүрсэлсэн байдаг. Хаадын онцгой бэлгэ тэмдэгт ийм шинж чанаруудыг Татбар хаан, Билгэ, Күлтегин болон бусад хөшөө дурсгалын орой дээр мөн адил чоно сийлсэн байдаг [Қыдырәлі .ред 2022: 86]. Мөн хаадын тахилын онгоны гол шинж тэмдэг болох тахилын тусгайлан зассан голдоо нүхтэй шоо чулуу “Номгон-2” цогцолбор дурсгалт газраас олдсон юм. Энэ нь түрэгийн хаадын тахилын онгоны гол шинж тэмдэг юм. Энэ үүднээс авч үзвэл «Номгон-2» цогцолбор дурсгал нь Орхоны алдарт дурсгалуудтай адил, эн зэрэгцэхүйц төвшинд орох хаадын дурсгалд тооцогдоно. Өгүүлэн буй тахилын гэрэлд хөшөөний согд болон эртний түрэг бичигт гарч буй Кутлуг хаан бол “Билгэ хаан, Күлтегин” жанжны эцэг бөгөөд зүүн түрэгийн хаант улсыг үүсгэн байгуулж олон хэлт нүүдэлчдийг нэгэн туган дор оруулж их улсыг байгуулсан хаан гэдэг нь бидний илрүүлэн олсон олон хэлний бичээс бүхий цогцолбор дурсгал юм.

Ном зүй

Баяр 2010 - Баяр Д. Новые находки археологических памятников древних тюрок в Монголии. – Uluslararası Zeki Velidi TOĞAN ve Türk Kültürü Sempozyumu. 13-15 Ekim, 2010 yılı, Afyon Kocatepe Üniversitesi. (Bildiri olarak sunulmuştur).

Баяр 2012 - Bayar Dovdoyn Moğolstanda Eski türklere ait yeni arkeolojik buluntular. – Uluslararası Türkçe Edebiyat Kültür Eğitim Dergisi Sayı: 1/1 2012 s.6-25, TÜRKİYE.

Баяр 2014 - Баяр Д. Новые находки археологических памятников древних тюрок в Монголии. – Баяр Д. Монголын дундад зууны археологийн судалгаа. Бүтээлийн эмхэтгэл. III боть (2004-2010 он). Эрхэлсэн доктор (Sc.), профессор Д.Цэвэндорж, эмхэтгэж хэвлэлд бэлдсэн Р.Мөнхтулга. -УБ: «Удам соёл» хэвлэлийн компани, УБ, 2014. Тал. 51

Очир нар. 2001 – Очир А, Энхтөр А. Номгоны хөндий дэх эртний түрэгийн онгон цогцолборууд. Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг. УБ, 2001. Тал. 25

Очир нар. 2009 - Очир А, Одбаатар Ц, Эрдэнэболд Л, Анхбаяр Б. Номгоны түрэг дурсгалууд. – Nomadic Studies. Нүүдэл судлал. УБ, 2009. Тал. 35-47.

Энхбат нар. 2012 – Энхбат Г, Даваацэрэн Б, Болд

Р. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Historical and Cultural Immovable Properties in Mongolia. VIII дэвтэр. Архангай аймаг. (Зохиогч: Г.Энхбат, Б.Даваацэрэн, Р.Болд) -УБ. Соёлын өвийн төв. УБ, 2012. Тал. 40, 41.

Энхбат нар. 2013 – Энхбат Г, Анхсанаа Г, Даваацэрэн Б. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Historical and Cultural Immovable Properties in Mongolia. X дэвтэр. Архангай аймаг. (Зохиогч: Г.Энхбат, Г. Анхсанаа, Б.Даваацэрэн) -УБ. Соёлын өвийн төв. УБ, 2013. Тал. 86

Мөнхтулга 2019 - Мөнхтулга Р. Тоньюкукийн гэрэлт хөшөөний бичээсийн айг хэмээх нэрийн тухай. – Ази судлал. Олон улсын эрдэм шинжилгээний тавдугаар хурал. Volume V. УБ, 2019. Тал. 633-637

Кыдырали 2019 - Кыдырали Д, Цэвээндорж Д, Энхтөр, А. Базылхан Н., Далантай С, Бөгенбаев Н, Буянхишиг Ц. «Номгон-2019» бірлескен экспедициясы археологиялык қазба зерттеулерінің ғылыми есебі. - Астана: Халықаралық түркі академиясы, Моңғолия Тарих, археология институты., 2019. Б-80.

Цэвээндорж 2019 - Цэвээндорж Д, Д.Кыдырали, Энхтөр А, Напил Б, Далантай С., Бөгенбаев Н., Буянхишиг Ц. Монгол улс-Олон улсын Түрэг академийн хамтарсан «Номгон» төслийн 2019 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. –УБ, 2019. Тал. 45

Jisl 1960 - Jisl L. Vyzkum Külteginova pamatnfku v Mongolske’ Lidove Republice // Archeologicke Rozhledy 1960. Pp. 64, 86-115

Сэр-Оджав 1979 - Сэр-Оджав Н. Хүл Тегиний булшнаас олсон хүн чулууны толгой. – Studia Archaeologica. Tomus. I, fasc. 6. УБ, 1979. Тал. 8.

Базылхан 2005 - Базылхан Н. Көне түркі бітіктастары мен ескерткіштері (Орхон, Енисей, Талас). – Серия: «Қазақстан тарихы туралы түркі деректемелері» -II том. –Алматы: Дайк-Пресс. 2005. Б-252 +144 жапсырма.

Қыдырәлі ред. 2022 – Қыдырәлі Д. Kültegin. Бітіктасы мәтіннің аудармалары: эзербайжан, қазақ, кыргыз, түрк, ттатар, тыва, моңғол, мажар, неміс, орыс, ағылшын, француз, корей, қытай тілдерінде. – Халықаралық Түркі академиясы: «Ғылым» баспасы, 2022. Б-368 (Бас ред. Д.Қыдырәлі, жауапты ред. Н.Базылхан).

Қыдырәлі ред. 2020 - Қыдырәлі.Д Тонықұқ. Бітіктасы мәтіннің аудармалары: эзербайжанша, қазақша, кыргызша, түркше, тываша, моңғолша, мажарша, немісше, орысша, ағылшынша, французша, қытайша. – Халықаралық Түркі академиясы: «Ғылым» баспасы, 2020. Б-125, (Бас ред. Д.Қыдырәлі, жауапты ред. Н.Базылхан).